



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МӨНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 08 сарын 08 өдөр

Дугаар A/353

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, амаржих газар, клиникт үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээний жагсаалт, журмын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Улсын хэмжээнд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж буй тусламж, үйлчилгээнийхээ чиглэлээр мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг холбоо, хувийн хэвшлийн оролцоог хангасан дэд ажлын хэсгийг байгуулж, тушаалын төслийг хэлэлцэн, нэгдсэн саналыг ажлын хэсэгт танилцуулахыг ажлын хэсэгт орсон эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын төслийг 2018 оны 4-р улиралд багтаан боловсруулж, батлуулахыг ажлын хэсгийн ахлагч, Бодлого төлөвлөлтийн газрын дарга /Р.Оюунханд/-д тус тус даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

Дэлхийн дэд ажлын хэсэг бийдэг Оюутнайд зөвшил

Эрүүл мэндийн сайдын  
2018 оны 08 сарын 28... өдрийн  
A/333 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

### Үндэслэл

"Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль"-ийн 8.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ДЭМБ-ын хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим, хүн төвтэй эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хүрээг баримтлан эмнэлгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын тусlamж, үйлчилгээний жагсаалт, журмын төсөлд олон талт мэргэжлийн оролцоог хангах шаардлагатай байна.

Энэхүү тушаалын төслийн зорилго нь Төрөөс эрүүл мэндийн талаарх бодлогын 2.4.2.5-д заасан "үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн тусlamж, үйлчилгээ"-г бий болгох, эмнэлгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээний хүртээмж, уялдаа холбоог хангах нөхцөл бүрдэнэ.

### Зорилго

Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, клиник, амаржих газарт үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээний жагсаалт, журмын төслийг эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг холбоодын саналыг тусган боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах

### Үйл ажиллагааны чиглэл

1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, клиник, амаржих газарт үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээний жагсаалт, журмын төслийг боловсруулах 40 худас 228 ажлын
2. Тушаалын төсөлд эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг холбоо, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын саналыг авч тусгах Дэд ажлын хэсэг байдлын, дэд тажилт франшизын
3. Тушаалын төслийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг тусган Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах

### Үр дүн

Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, клиник, амаржих газарт үзүүлэх эмнэлгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээний жагсаалт, журмын төслийг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна.

1)  
ii) Хамгийн оршидүүжүүлдэг  
iii) Амь товтолтойт тусгийн жижиг  
Задчилсан франшиид хувь 62.2. Нийтиг ажлын сонирхолтой  
хүчинд фз.